



НИЙСЛЭЛИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 5/11

Улаанбаатар хот

Балансын урамшуулал
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2006 оны 292, 2012 оны 294 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжид заасан хугацаанд стандартын дагуу гаргаж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын шалгалтаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан Ахлах нягтлан бодогч П.Ариунцэцэг, нярав Б.Болорлхам нарыг 1 (нэг) сарын үндсэн цалинтай тэнцэх балансын урамшуулалыг тус тус олгосугай.

2.Урамшууллын зардлыг батлагдсан төсөвт багтаан цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (П.Ариунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.ГАНБОЛД

